

МИК ХОЛДИНГ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТӨГТООЛ

20... 21 ...
ноны 04 сарын 29
жедэр

№ 21/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн дүрэмд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:
 - 1.1. 3.2-т “Компани нь өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үйл ажиллагаатай шууд буюу шууд бус холбоотой, хууль тогтоомжид хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагаа эрхлэх болон ажил гүйлгээг хийх бүрэн эрхтэй байна.” гэснийг хасах;
 - 1.2. 4.1-т “Компанийн хараат болон охин компанийн хувьцааг эзэмшин, удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулах бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ.” гэснийг хасах;
 - 1.3. 4.1-т “Компанийн эрхлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл нь:
 - 4.1.1. Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа;
 - 4.1.2. Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа;
 - 4.1.3. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
 - 4.1.4. Бизнесийн зөвлөгөө өгөх үйлчилгээ;
 - 4.1.5. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа;
 - 4.1.6. Санхүүгийн бусад үйлчилгээ.” гэж нэмэх;
 - 1.4. 4.2-т “Компанийн өөрийн зорилго болон эрхлэх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй шууд болон шууд бус холбоотой, хууль тогтоомжид хориглоогүй бүхий л төрлийн үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааг эрхлэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ.” гэж нэмэх;
 - 1.5. 9.1-т “...“ТҮЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох...” гэснийг “...дотоод журмаар...” гэж өөрчлөх;
 - 1.6. 9.7.20-т “Гүйцэтгэх удирдлага болон ТҮЗ-ийн гишүүдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлуу” гэснийг “9.7.20. Гүйцэтгэх удирдлагын гаргасан хүсэлтээр хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд”, “9.7.21. “ТҮЗ-ийн дэргэдэх хороо, эсвэл ТҮЗ-ийн гишүүдийн саналаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд” гэж өөрчлөх;
 - 1.7. 9.7.21 дэх заалтыг 9.7.22 дахь заалт болгож өөрчлөх;
 - 1.8. 9.8-д “...Гүйцэтгэх удирдлагын санаачилгаар...” гэснийг “...Гүйцэтгэх удирдлагын хүсэлтээр...” гэж өөрчлөх;
 - 1.9. 14.3-т “ТҮЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвишүүлэх хороотой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТҮЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.” гэснийг “ТҮЗ нь аудит, цалин, урамшуулал, нэр дэвишүүлэх болон эрсдэлийн удирдлагын хороотой байх бөгөөд аудит, цалин, урамшуулал болон нэр дэвишүүлэх хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТҮЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.” гэж өөрчлөх;

- 1.10.14.4-т “ТҮЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааг ТҮЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно.” гэснийг хасах.
2. Энэ тогтоолын 1-т заасан нэмэлт, өөрчлөлтийн талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлэх болон улсын бүртгэлд бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
 3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



М.МОНХБААТАР

★★